



АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Ашигт малтмалын тухай хууль нь геологи, уул уурхайн салбарын харилцааг зохицуулдаг, салбарт оролцогчдын эрх ашгийг тэгш хангаж, байгаль орчин, хөрөнгө оруулалтын эрх зүйн харилцааны харилцан уялдааг нарийн зохицуулсан байдаг бөгөөд түүнийг бусад хуультай нийцүүлэн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах шаардлага хэдийнээ үүсээд байна.

Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2006 онд 11 бүлэг, 66 зүйлтэйгээр баталсан бөгөөд хууль хэрэгжих хугацаанд 16 удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр 11 бүлэг, 59 зүйлийн хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт орсон байна. Энэ нь хуулийн зохицуулалтыг сайжруулах чиглэлд тодорхой ахиц гарсан ч хуулийн оновчтой зохицуулалт дутагдаж, улс орны эдийн засгийн тэргүүлэх салбарын хөгжлийг сааруулах, өрсөлдөх чадварыг алдагдуулах, улмаар хөрөнгө оруулалтыг бууруулах эрсдэлд хөтөлж байна. Ерөнхийд нь авч үзвэл анх батлагдсан хуулийн үзэл баримтлал эрс өөрчлөгдсөн гэж үзэж болохоор байна.

Монгол Улсын Үндсэн Хууль, Монгол Улсын нийгэм, эдийн засаг, эрх зүйн харилцаанд гарсан томоохон өөрчлөлтүүд, Монгол Улсын хөгжлийн бодлогын тулгуур болсон эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгох зорилт зэрэг нь хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага үүсээд байгааг харуулж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д зааснаар хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний дагуу Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байгааг тодорхойлж байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг хуулийн Зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.1-д “...ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэн хөрөнгө оруулалтыг татах боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авахаар заасан бөгөөд уг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалт болон өргөдлөөр олгох үйл ажиллагааг цахимжуулж, хайгуулын ажилд зарцуулах хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эрдэс баялгийн нөөцийг арвижуулж, нэмүү өртөг шингэсэн хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлнэ” гэж хүрэх үр дүнг тодорхойлсон.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.1-д зааснаар “Нөөц ашигласны төлбөр, бусад төрлийн татварын зохицуулалтыг боловсронгуй болгох, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талаарх зохицуулалтыг боловсронгуй болгох, Засгийн газар байгалийн баялгийг ашиглах шийдвэр гаргах зарчим, журмыг боловсронгуй болгох, онцгой ач холбогдол бүхий зарим асуудлаар иргэдтэй зөвлөлдөх, тэдгээрийн саналыг авч тусгах механизмыг тодорхой болгож, уялдаа холбоог нь хангах, ашигт малтмал хайх, олборлох, ашиглах явцад байгалийн тэнцлийг хангах, нөхөн сэргээх, эдгээрт үйл ажиллагаанд оролцогчийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох” чиглэлээр хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.1.2-т “Геологийн судалгаа, эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэн, шинэ орд газруудыг нээж, газрын хэвлийн нэгдсэн геомэдээллийн санг бүрдүүлнэ” гэж заасан.

Эдгээр нь Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Монгол Улсын эдийн засаг нь бүхэлдээ уул уурхайгаас хамааралтай бөгөөд нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийг ашиглах бодлого нь уул уурхайг дагасан эдийн засгийн бусад салбарыг дэмжих замаар улс орны нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх шаардлагатайг хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тодорхой заасан.

Иймээс ч хязгаарлагдмал нөөцийг хариуцлагатайгаар, үр дүнтэйгээр ашиглахад хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Зарим улс орон өөрийн үндэсний аюулгүй байдал болон үйлдвэржилт, олон улсын шинэ технологид шаардлагатай, эрэлт хэрэгцээ ихтэй ашигт малтмалыг “чухал” бүлэгт хамруулан зарлаж тухайн төрлийн ашигт малтмалыг эрэх, хайх, ашиглах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд тусгайлан бодлого гарган хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хувьд чухал ашигт малтмалын нэр төрлийг тодорхойлж, түүнтэй холбоотой асуудлыг улсын хөгжлийн бодлогод тусгайлан тусгаж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны горимтой байх нөхцлүүдийг хуулиар зохицуулах шаардлага тулгамдаж байна.

Гарал үүсэлгүй хүдрийг худалдан авч хууль бус олборлолтыг өөгшүүлэх, татвар төлөхөөс зайлсхийх, баяжуулалтын дүрэм журам, технологи, стандарт, норм зөрчигдөх, хортой бодис урвалжийг ил, далд байдлаар хяналтгүй ашиглах, хүрээлэн буй орчинд эрсдэл үүсгэх зэрэг олон сөрөг үр дагаварыг арилгах үүднээс тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал баяжуулах үйл ажиллагаа эрхэлж байгаа харилцааг эрх зүйн зохицуулалттай болгох, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй байх, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээдийн үйл ажиллагаанаас үүссэн үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглахаар хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Бүх шатны нутгийн захиргааны байгууллага болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын эрх, үүрэг уялдаагүй, давхардалтай, эсхүл тодорхойгүйгээс салбарт оролцогчдын хооронд үл ойлголцол үүсэх, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтны эс үйлдэхүй түгээмэл гарах болсны дээр зохион байгуулалттай эсэргүүцлийн ажиллагаа газар авч, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг зогсоох, энэ нь цаашлаад улс орон нутгийн төсвийн орлогыг тасалдуулах хүртэл сөрөг үр нөлөөг үзүүлж байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож байгаа нь тэгш шударга, нээлттэй байх зарчмыг хангаж байгаа хэдий ч зарлагдаж буй талбайд санал ирэхгүй байх, нэг талбайд нэг санал ирэх зэрэг тохиолдлын эзлэх хувь 40-46 хувьтай байгаагаас сонгон шалгаруулалт зарлаж буй талбайнууд хэтийн төлөвгүй буюу хөрөнгө оруулагчдын сонирхож буй талбай зарлагдахгүй байгааг илтгэж байна.

Иймээс хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргах, олгох үйл ажиллагааны зохицуулалтыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.

Мөн бичил уурхай эрхлэгч нөхөрлөл, хоршоог ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч этгээд байхаар, тухайн жилийн тайланг холбогдох байгууллагад хүргүүлдэг байхаар зохицуулалтыг тусгах шаардлага байна.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь технологийн хувьд ялган авах боломжгүй болон төлбөр төлдөг хорт хольцод тооцогддог дагалдах элементэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулж байгаа уул уурхайн салбарт бизнес эрхлэгчдийн хувьд хүндрэл үүсгэж байгаа бөгөөд үүнийг олон улсын жишгийг харгалзан боловсронгуй болгох шаардлагатай.

Эдгээр нь Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах практик шаардлага болно.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.1-д заасны дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр боловсруулах бөгөөд дараах асуудлыг тусгана:

-Чухал ашигт малтмалыг тодорхойлж түүний хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны талаар;

-Баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг зэрэг баяжуулах үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой харилцаа;

-Хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох, зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, түүнийг бүртгэх, өргөдлийг хянан шийдвэрлэх журам;

-Нутгийн захиргааны байгууллагатай харьцах, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, тусгай зөвшөөрлийн төлбөр, бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбоотой зохицуулалт;

-Засгийн газар, төрийн захиргааны байгууллага, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүргийн талаар;

-Түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглахтай холбоотой зохицуулалт.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, эрх зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан хувийн өмчийн эрхийг зөрчихгүйгээр, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Уул уурхайн салбарт бизнес эрхлэгчдийн хувьд үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин тодорхой болж, бизнес эрхлэх таатай, тогтвортой орчин бүрдэнэ.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа эрчимжиж, Монгол Улсын газрын хэвлийн баялгийн нөөц нэмэгдэж, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр нийгэм, эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Зарим төрлийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах хувийг оновчтой тогтоох зэрэг салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хамарсан эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтийг бий болгоно.

Тусгай зөвшөөрлийн төлбөрийг нэмэгдүүлэх, баяжуулах үйлдвэр нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулснаар хариуцлагатай уул уурхайн тогтолцоо улам бэхжинэ. Ингэснээр салбарын талаарх олон нийтийн ойлголт, итгэл нэмэгдэж, эсэргүүцэл багасна.

Дөрөв.Хуулийн төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүйд тооцох хууль тогтоомжийн талаар

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулагдан Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцсэн байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг дагалдуулан боловсруулна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуульд доор дурдсан агуулгатай бүлэг, зүйл, хэсэг, заалт нэмсүгэй.

1/4 дүгээр зүйлийн 4.1.32-4.1.43 дахь заалт:

“4.1.32. “чухал ашигт малтмал” гэж олон улсын шинэ технологид шаардлагатай, эрэлт хэрэгцээ ихтэй ашигт малтмалыг;

4.1.33. “түгээмэл тархацтай ашигт малтмал” гэж элбэг тархалт бүхий нуурын давс, хужир, шүү, шавар, элс, хайрга, дайргын зориулалттай барилгын чулуу, боржин, хүрмэн чулуулгийн хуримтлалыг;

4.1.34. “үндсэн ашигт малтмал” гэж ашигт малтмалаас технологи, эдийн засгийн хувьд ашигтайгаар ялгаж авах бололцоотой эрдэс, химийн элементийг;

4.1.35. “эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмал” гэж химийн нэгдлийн хувьд үндсэн ашигт малтмалтай хамт үүсэж, хуримтлагдсан, дараагийн шатны технологийн боловсруулалтаар эдийн засгийн үр ашигтай ялган авах боломжтой эрдэс, химийн элементийг;

4.1.36. “баяжуулалтын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуулийн дагуу төрөөс олгосон баяжуулалтын үйл ажиллагаа явуулах эрхийг;

4.1.37. “баяжуулалтын үйл ажиллагаа” гэж баяжуулалтын технологи ашиглаж газрын хэвлийн баялагт агуулагдах ашигт бүрдвэрийн агуулга, чанарыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг;

4.1.38. “техник, эдийн засгийн үндэслэл” гэж уул уурхайн төслийг хэрэгжүүлэхэд чиглэсэн техник, технологийн шийдэл, эдийн засгийн үр ашиг болон холбогдох бусад хүчин зүйлийг нарийвчлан тооцсон ашигт малтмалын орд болон түүний хэсгийг ашиглах, баяжуулах үйл ажиллагааг тусгасан баримт бичгийг;

4.1.39. “зураг төсөл” гэж уурхай, үйлдвэрийн технологийн байгууламж, тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, дэд бүтцийн төлөвлөлт, үйл ажиллагааг иж бүрэн, нарийвчлан тооцсон баримт бичгийг;

4.1.40. “зураг төсөл боловсруулах зөвшөөрөл” гэж технологийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах хуулийн этгээдэд олгох эрхийг;

4.1.41. “маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл” гэж геологи, уул уурхайн үйл ажиллагааны төлөвлөлт, хяналтад шаардагдах хэмжилт, зураглалын ажил хийх хуулийн этгээдэд олгох эрхийг;

4.1.42.“бизнесийн таатай орчин” гэж төсөл хэрэгжүүлэгчийн хөрөнгө, газар, хүний нөөц, дэд бүтэц, нийтийн хэрэгцээг хангах болон ажиллагсдын бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн, тогтвортой, үр ашигтай орчныг;

4.1.43.“дэмжих дэд бүтэц” гэж судалгаа хөгжүүлэлт, бизнес эрхлэлтийг дэмжих, техникийн болон мэргэжлийн сургалтын зориулалтаар ашиглах, төсөл хэрэгжүүлэгч, төр, өмчийн бусад этгээдийн хамтын ажиллагааг дэмжих байгууламжийг;”

2/5 дугаар зүйлийн 5.9 дэх хэсэг:

“5.9.Энэ хуулийн 8.1.4-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үүсмэл ордыг бусдад гэрээний дагуу ашиглуулж болох бөгөөд тусгай зөвшөөрлийн талбайн хил заагт багтаж байгаа үүсмэл ордыг бусдад шилжүүлэхийг хориглоно.”

3/8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалт:

“8.1.8.чухал ашигт малтмалын жагсаалтыг батлах;

4/9 дүгээр зүйлийн 9.1.19 дэх заалт:

9.1.19.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын жагсаалтыг ордын онцлог болон олон улсын жишгийг харгалзан геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн үндсэн ашигт малтмалын төрөл тус бүрээр Засгийн газар батална.”

5/10 дугаар зүйлийн 10.1.21, 10.1.22, 10.1.23 дахь заалт:

“10.1.21.техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлагыг батлах;”

10.1.22.Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр улсын төсөв, Засгийн газрын зээл, бондын хөрөнгөөр, эсхүл Засгийн газраас баталгаа гарган хэрэгжүүлэх эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр болон авто зам, замын байгууламж барих, засварлах үйл ажиллагаад шаардлагатай түгээмэл, тархацтай ашигт малтмал ашиглах асуудлыг ажлын 14 хоногт шийдвэрлэх;

10.1.23.энэ хуулийн 10.1.22-т заасан түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээний загварыг батлах;”

10.1.24.маркшейдерийн үйл ажиллагаа эрхлэх, уул уурхайн технологийн зураг төсөл боловсруулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагааны журам батлах;

6/11 дүгээр зүйлийн 11.1.29 дэх заалт:

“11.1.29.энэ хуулийн 10.1.22-д заасан түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах талбайн солбицлыг хянах, дүгнэлт гаргах, гэрээ байгуулах;”

7/11¹ дүгээр зүйлийн 11¹.2 дахь хэсэг:

“11¹.2.Тухайн орон нутагт хэрэгжүүлэх нэн шаардлагатай геологийн салбарын бүх төрлийн судалгааны төсөл хөтөлбөрт нутгийн захиргааны байгууллага болон иргэдийн саналыг тусгах, боловсруулах төлөвлөлт хийх, гүйцэтгэлд оролцох;”

8/12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг:

12.3. Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаанд Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.3.1.энэ хуулийн 10.1.22, 10.1.23-т заасан түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээг байгуулж, олборлолт, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд хяналт тавих;

12.3.2.авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг энэ хуулийн 12.3.2.а, 12.3.2.б-д заасан дүнгээр тооцож орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.

12.3.2.а.төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр барих болон тусгай зориулалтын авто зам барихад ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр тооцох борлуулалтын үнэлгээ нэг шоо метр тутамд 5000 төгрөгөөс хэтрэхгүй байна.

12.3.2.б.улсын болон орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих авто болон төмөр зам, замын байгууламжийн барилга, их засвар, ээлжит засвар, арчлалтын ажилд ашиглах түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр тооцох борлуулалтын үнэлгээ нь нэг шоо метр тутамд 1 төгрөг байна.

9/12¹ дүгээр зүйл:

“12¹ дүгээр зүйл.Орон нутгийн дэмжлэг

12¹.1.Ашигт малтмалын эрэл, хайгуул хийх, олборлолт явуулах, боловсруулалт хийх, үйлдвэр дэд бүтэц барих, газар, усны нөөц ашиглахад орон нутгаас дэмжлэг үзүүлнэ.

12¹.2.Энэ хуулийн 12¹.1-т заасан дэмжлэгийг үзүүлэхгүй бол геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн захиргаанаас асуудлыг тодруулах, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын хуралдаанд асуудлыг танилцуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулна.”

10/17 дугаар зүйлийн 17.8, 17.9 дэх хэсэг:

“17.8.Хайгуулын тусгай зөвшөөрлийг өргөдлөөр олгох талбайд дараах талбайг хамруулна:

17.8.1.улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны үр дүнгээр ашигт малтмалын хэтийн төлөвгүй;

17.8.2.нөөц тогтоогдоогүй буюу ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдоогүй, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, эсэх нь тодорхойгүй, эдийн засгийн үр ашиг болон баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдоогүй;

17.8.3.хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг хоёр удаа зарласан боловч сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт ирээгүй.

17.9.Энэ хуулийн 17.8-д заасан талбайн солбицлыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтоож, нийтэд мэдээлнэ.”

11/18 дугаар зүйлийн 18.1.9 дэх заалт:

“18.1.9.төрийн захиргааны байгууллагаас батлагдсан загварын дагуу үйлдсэн талбайн зураг.”

12/18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг:

“18.3.Энэ хуулийн 18.1-д заасан баримт бичгийг цахим хэлбэрээр хүсэлт хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээнэ.”

13/18¹ дүгээр зүйл:

“18¹ дүгээр зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах, түүнийг бүртгэх

18¹.1.Энэ хуулийн 17.9-т заасны дагуу Засгийн газраас нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч эхлэх хугацааг төрийн захиргааны төв байгууллагаас нийтэд зарлана.

18¹.2.Энэ хуулийн 18¹.1-д заасан өргөдлийг төрийн захиргааны байгууллагын баталсан маягтын дагуу гаргах бөгөөд дараах бичиг баримтыг хавсаргана:

18¹.2.1.өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, цахим шуудангийн хаягийг тусгасан өргөдөл гаргагчийн албан ёсны мэдээлэл;

18¹.2.2.энэ хуулийн 7.1-д заасан шаардлага хангасныг нотлох тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрэм болон татвар төлөгчийн гэрчилгээний хуулбар;

18¹.2.3.үйлчилгээний хөлс төлсөн баримт;

18¹.2.4.төрийн захиргааны байгууллагаас батлагдсан загварын дагуу үйлдсэн, хайгуулын тусгай зөвшөөрөл авах хүсэлтэй байгаа талбайн зураг, солбицол.”

14/20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэг:

“20.9.Сонгон шалгаруулалтаар олгох хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн босго үнэ нэг гектар тутамд 7,000 төгрөг байна.”

15/20¹ дүгээр зүйл:

“20¹ дүгээр зүйл.Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх

20¹.1.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 18¹.2-т заасан шаардлага хангасан өргөдлийг хүлээн авмагц ажлын 10 өдрийн дотор дор дурдсан ажиллагааг гүйцэтгэнэ:

20¹.1.1.өргөдөл гаргагчаас ирүүлсэн хүсэлтийг хугацаагаар нь дугаарлан бүртгэж, хүлээн авсан баримтыг өргөдөл гаргасан этгээдэд өгөх;

20¹.1.2.өргөдөл, түүнд хавсаргасан бичиг баримт нь энэ хуулийн 18¹.2-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шүүнэ;

20¹.1.3.өргөдөл гаргасан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон буюу түрүүлж ирүүлсэн өргөдөлд дурдсан талбайтай давхцаж байгаа, эсэхийг тогтооно.

20¹.2.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20¹.1-д заасан хугацааны дотор дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

20¹.2.1.өргөдөл гаргагч болон түүний гаргасан өргөдөл нь энэ хуулийн 7.1, 20¹.1.2-т заасан шаардлагыг хангасан, өргөдөл гаргасан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай давхцалгүй бол уг талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтойг өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэж, энэ хуулийн 20¹.3-т заасан ажиллагааг гүйцэтгэнэ;

20¹.2.2.өргөдөл гаргасан талбай нь түрүүлж ирүүлсэн өргөдөлд заасан талбайтай эсхүл ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай хэсэгчлэн давхацсан бол давхцаагүй хэсэгт нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтойг бичгээр мэдэгдэх бөгөөд уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор өргөдөлдөө өөрчлөлт оруулах боломжийг олгоно. Уг хугацааны дотор өргөдөл гаргагч хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайн хэмжээгээр өргөдөлдөө өөрчлөлт оруулан ирүүлсэн тохиолдолд төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20¹.4-т заасан ажиллагааг гүйцэтгэнэ;

20¹.2.3.өргөдөл гаргагч энэ хуулийн 7.1-д заасан шаардлагыг, мөн гаргасан өргөдөл нь 20¹.1.2-т заасан шаардлагыг хангаагүй, эсхүл өргөдөл гаргасан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ давхацсан бол хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжгүйг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

20¹.3.Төрийн захиргааны байгууллага өргөдөл гаргасан талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргаж, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг мөн хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөх тухай өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.

20¹.4.Хайгуулын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлөөгүй бол төрийн захиргааны байгууллага өргөдлийг бүртгэлээс хасаж өргөдөл гаргасан этгээдэд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

20¹.5.Өргөдөл гаргасан этгээд эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлсөн бол төрийн захиргааны байгууллага ажлын 3 өдөрт багтаан хайгуулын тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгож, хайгуулын тусгай зөвшөөрөл болон олгогдсон талбайг тусгай зөвшөөрлийн болон түүний зураг зүйн бүртгэлд бүртгэнэ.

20¹.6.Хайгуулын тусгай зөвшөөрөлд түүнийг олгосон он, сар, өдөр, эзэмшигчийн нэр, талбайн хэмжээг тэмдэглэх бөгөөд олгогдсон талбайн булангийн цэгийн солбицол, тусгай зөвшөөрөлтэй холбоотой өөрчлөлтийг тусгах зориулалт бүхий хавсралттай байна.

20¹.7.Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, татварын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.”

16/21 дүгээр зүйлийн 21.1.9 дэх заалт:

“21.1.9.хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд гүйцэтгэсэн ажлын мэдээллийг нийтэд цахимаар ил тод мэдээлэх;”

17/25 дугаар зүйлийн 25.1.9 дэх заалт:

“25.1.9.техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж хүлээн авсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, төрийн захиргааны байгууллагын шийдвэр;”

18/27 дугаар зүйлийн 27.1.15, 27.1.16 дахь заалт:

“27.1.15.тусгай зөвшөөрлийн талбайгаас өөрийн төслийн бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалыг ашиглах;

27.1.16.энэ хуулийн 10.1.22-т заасан журмын дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах эрх авсан хуулийн этгээд нь тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх болон байгаль орчны нөхөн сэргээх үүргээс чөлөөлөгдөхгүй.”

19/ДӨРӨВДҮГЭЭР¹ БҮЛЭГ:

**“ДӨРӨВДҮГЭЭР¹ БҮЛЭГ
АШИГТ МАЛТМАЛЫН БАЯЖУУЛАЛТ**

28¹ дугаар зүйл.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох, түүнд тавигдах шаардлага

28¹.1.Баяжуулалтын үйл ажиллагааг баяжуулалтын тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхэлнэ.

28¹.2.Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч баяжуулалтын үйл ажиллагааг эрхлэх тохиолдолд энэ хуулийн 28¹.1-д заасан баяжуулалтын тусгай зөвшөөрөл шаардахгүй.

28¹.3.Ашиглалт, баяжуулалтын үйл ажиллагааны явцад үүсэх үүсмэл ордыг бусад этгээд ашиглах тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ашиглана.

28¹.4.Баяжуулалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргагч энэ хуульд зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

28¹.4.1.технологийн болон хагас үйлдвэрлэлийн туршилтыг холбогдох стандарт, аргачлалын дагуу хийлгэсэн;

28¹.4.2.газар ашиглах эрхийн гэрчилгээтэй;

28¹.4.3.баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд энэ хуулийн 48.4-д заасны дагуу холбогдох шийдвэрийг гаргуулсан;

28¹.4.4.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг батлуулсан;

28¹.4.5.ус хангамжийн асуудлыг шийдвэрлэсэн.

28¹.5.Энэ хуулийн 28¹.4-т заасан шаардлага хангасан тохиолдолд баяжуулалтын тусгай зөвшөөрлийг 10 жилийн хугацаагаар олгож, мөн хугацаагаар 3 удаа сунгаж болно.

28² дугаар зүйл.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

28².1.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх эдэлнэ:

28².1.1.баяжмал, бүтээгдэхүүнээ худалдах;

28².1.2.тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах;

28².1.3.тусгай зөвшөөрөл эзэмшигч зохих татварыг төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд тусгай зөвшөөрлийг шилжүүлэх;

28².1.4.энэ хуульд заасан бусад.

28².2.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүрэг хүлээнэ:

28².2.1.үйл ажиллагааны талаар олон нийтэд жил бүр мэдээлэх;

28².2.2.химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу саармагжуулах, устгах;

28².2.3.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бүрэн төлөх;

28².2.4.баяжуулах үйлдвэрийн хүчин чадал, тоног төхөөрөмж, технологи өөрчлөгдсөн тохиолдолд техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийх;

28².2.5.энэ хуульд заасан бусад.

28².3.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь техник, эдийн засгийн үндэслэл болон тухайн тусгай зөвшөөрөлд тэмдэглэснээс бусад төрлийн ашигт малтмал, гарал үүсэл нь тодорхойгүй ашигт малтмал баяжуулж, борлуулахыг хориглоно.

28².4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байх хугацаанд энэ хуулийн 28¹.4-т заасан шаардлагыг хангаж ажиллана.

28³ дугаар зүйл.Баяжуулалтын үйл ажиллагаа эрхлэх

28³.1.Баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрөл олгогдсон өдрөөс хойш 90 хоногийн дотор техник, эдийн засгийн үндэслэлд тусгасан технологийн дагуу үйлдвэр барьж байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад энэ хуулийн 48.6.2-т заасан хугацаанд хүргүүлнэ.

28³.2.Энэ хуулийн 28³.1-д заасан төлөвлөгөөний хүрээнд дэд бүтцийг бий болгож, үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай барилга байгууламжийг барьж байгуулж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг угсарч суурилуулан, туршилт, тохируулга хийж, хэвийн ажиллагаанд бэлтгэнэ.

28³.3.Энэ хуулийн 28³.2-т заасан бэлтгэл ажлын хүрээнд хийгдэх ажил, бүрдүүлэх бичиг баримтыг энэ хуулийн 10.1.11-д заасны дагуу зохицуулна.

28³.4.Баяжуулах үйлдвэрийн бүтээгдэхүүн нь чанарын хувьд Монгол Улсын стандартад нийцсэн байна.

28³.5.Энэ хуулийн 28³.5-д заасан бүтээгдэхүүний чанарыг Монгол Улс эсхүл гадаад улсад итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээр тодорхойлно.”

20/30¹ дүгээр зүйл:

“30¹ дүгээр зүйл.Чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа

30¹.1.Чухал ашигт малтмалын хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг энэ хуулийн 3, 4 дүгээр бүлэгт заасны дагуу зохицуулна.

30¹.2.Чухал ашигт малтмалын төслийг дэмжих тухай бодлогыг хөгжлийн бодлогын баримт бичигт тусган батална.

30¹.3.Чухал ашигт малтмалын төсөлд бизнесийн таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дараах дэмжлэгийг үзүүлнэ:

30¹.3.1.боловсрол, сургалт, үйлдвэржилтийн хүний нөөцийн хөгжлийг дэмжих;

30¹.3.2.аж ахуйн нэгжийн чадавхыг дэмжих;

30¹.3.3.технологи ба инновацыг дэмжих;

30¹.3.4.санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх;

30¹.3.5.газар, дэд бүтцийн дэмжлэг үзүүлэх;

30¹.3.6.дотоодын зах зээлийг хамгаалах;

30¹.3.7.гадаад худалдаа, экспортыг дэмжих;

30¹.3.8.гадаадын шууд хөрөнгө оруулалт татах;

30¹.3.9.олон улсын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийн сүлжээнд нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэх.

30¹.4.Энэ хуулийн 30¹.3-д заасан дэмжлэг эдлэх хүсэлтийг чухал ашигт малтмалын төсөл хэрэгжүүлэгч нь геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар дамжуулан гаргана.

30¹.5.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь холбогдох хүсэлтийг нэгтгэн, асуудал хариуцсан төрийн болон орон нутгийн байгууллагад уламжлан шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.”

21/32 дугаар зүйлийн 32.4, 32.5 дахь хэсэг:

“32.4.Энэ хуулийн 32.2, 32.3 дахь хэсэгт заасан нэгж нь 400 төгрөгтэй тэнцүү байна.

32.5.Баяжуулалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь жил бүр 10,000,000 төгрөг байна.”

22/42¹ дүгээр зүйл:

“42¹ дүгээр зүйл.Орон нутгийн оролцоо

42¹.1.Хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны мэдээлэл олон нийтэд нээлттэй байх бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагааныхаа талаар тогтмол мэдээлж тайлагнана.

42¹.2.Иргэн, төрийн бус байгууллага геологи, уул уурхайн салбарын үйл ажиллагаанд дараах хэлбэрээр оролцоно:

42¹.2.1.салбарын хууль тогтоомж, хөгжлийн бодлого, захиргааны хэм хэмжээний акт боловсруулах хэлэлцүүлэгт оролцох, санал, зөвлөмж өгөх;

42¹.2.2.салбарын байгууллагуудтай хамтарсан судалгаа хийх;

42¹.2.3.салбарын хүний нөөц, техник, технологийн хөгжил, чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр шилдэг туршлага, ололтыг нэвтрүүлэхэд төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах;

42¹.2.4.холбогдох төрийн байгууллагаас геологи, уул уурхайн салбарын талаар үнэн, зөв мэдээлэл авах;

42¹.2.5.эдийн засгийг хөгжүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр геологи, уул уурхайн салбарт төрөөс баримталж буй бодлогыг дэмжих, энэхүү бодлогыг алдагдуулах, зогсоох аливаа явцуу ашиг сонирхолд оролцохгүй байх;

42¹.2.6.ашигт малтмал хайх, ашиглах, баяжуулах үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, амьдрах орчин, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэж байгаа, хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаар эрх бүхий албан тушаалтан, төрийн байгууллагад мэдэгдэх, гомдол гаргах.

23/42 дугаар зүйлийн 42.7 дахь хэсэг:

“42.7.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал, Засаг дарга, холбогдох бусад

төрийн байгууллага ашигт малтмалын хайгуул, ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах үүрэгтэй.”

24/47 дугаар зүйлийн 47.1.4 дэх заалт:

“47.1.4.бичил уурхай эрхлэгч;”

25/47 дугаар зүйлийн 47.20 дахь хэсэг:

“47.20.Үндсэн ашигт малтмалын тухайн төрөлд дагалдах байдлаар агуулагдаж байгаа, энэ хуулийн 9.1.20-д заасан жагсаалтад заагдаагүй эрдэс, химийн элементэд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулахгүй.

26/48 дугаар зүйлийн 48.6.4 дэх заалт:

“48.6.4.ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн ажлын тухайн жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор;”

27/48 дугаар зүйлийн 48.15 дахь хэсэг:

“48.15.Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон тайланг жил тутамд батлагдсан маягтын дагуу гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор, аймаг, нийслэлийн Засаг дарга нэгтгэн ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлнэ.”

2 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн гарчгийн “эрх” гэсний дараа “, үүрэг” гэж, 35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсгийн “Ашиглалтын” гэсний дараа “болон баяжуулалтын” гэж 47.14 дэх хэсгийн “олон улсын” гэсний өмнө “дотоодын болон” гэж, 48 дугаар зүйлийн 48.6.2 дахь заалтын “төлөвлөгөөг” гэсний өмнө “болон баяжуулах үйлдвэрийн” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг тус тус өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт:

“4.1.2."цацраг идэвхт ашигт малтмал" гэж уран болон торийн бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан газрын ховор элементүүдээс бусад эрдэс баялгийн хуримтлалыг;”

2/4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалт:

“4.1.12."стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд" гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засагт нөлөөлөхүйц, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг;”

3/4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалт:

“4.1.23."бичил уурхай эрхлэх" гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг;”

4/7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг:

“7.1.Хайгуул, ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрлийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдан Монгол Улсад татвар төлөгч хуулийн этгээдэд олгоно.”

5/11 дүгээр зүйлийн 11.1.19 дэх заалт:

“11.1.19.цацраг идэвхт ашигт малтмалаас бусад төрлийн ашигт малтмалын хайгуул, ашиглалт болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл олгох;”

6/11 дүгээр зүйлийн 11.1.25 дахь заалт:

“11.1.25.энэ хуулийн дагуу ашигт малтмалын хайгуулын өргөдлөөр болон сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайг солбицлоор тодорхойлох, батлуулах;”

7/11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг:

“11.2.Төрийн захиргааны байгууллагын геологийн асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.1–11.1.7, уул уурхайн асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.8 – 11.1.12, 11.1.30, кадастрын асуудал хариуцсан нэгж нь энэ зүйлийн 11.1.13–11.1.29-д заасан асуудлыг эрхэлнэ.”

8/18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт:

“18.1.1.Сонгон шалгаруулалтад оролцогч хуулийн этгээдийн нэр, шуудангийн хаяг, утас, цахим шуудангийн хаягийг тусгасан албан ёсны мэдээлэл;”

9/18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалт:

“18.1.6.энэ хуулийн 7.1-д заасан шаардлага хангасныг нотлох баримт;”

10/32 дугаар зүйлийн 32.2, 32.3 дахь хэсэг:

“32.2.Хайгуулын тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр нь эхний 3 жилд хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн гектар тутамд 10 нэгж, 4, 5, 6 дахь жилд 40 нэгж, 7, 8, 9 дэх жилд 70 нэгж, 10, 11, 12 дахь жилд 100 нэгж байна.

32.3.Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр нь талбайн гектар тутамд жил бүр нүүрс, шохойн чулуунд болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хувьд гектар тутамд жил бүр 30 нэгж, бусад ашигт малтмалын хувьд 120 нэгж байна.”

11/35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэг:

“35.4.Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон комисс уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авсны дараа ашиглалтын болон баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ажиллуулж эхэлнэ.”

12/42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг:

“42.1.Ашиглалт, баяжуулалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчныг хамгаалах, уурхай, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж өгөх асуудлаар орон нутагтай хамтран ажиллах гэрээг сум, дүүргийн Засаг даргатай байгуулж, аймаг, нийслэлийн Засаг дарга баталгаажуулна.”

13/47 дугаар зүйлийн 47.5 дахь хэсгийн хүснэгтийн 1 дэх мөр:

№	Ашигт малтмалын нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллар/	Боловсруулалтаас хамаарч суурь төлбөр дээр нэмж ногдуулах хувь		
					Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
1	Зэс	тн	Зэс /цэвэр металлаар	0-5000 хүртэл	0.00	0.00	0.0
				5000-6000 хүртэл	11.0	1.0	0.5
				6000-7000 хүртэл	12.0	2.0	1.0
				7000-8000 хүртэл	13.0	3.0	1.5
				8000-9000 хүртэл	14.0	4.0	2.0
				9000 ба түүнээс дээш	15.0	5.0	2.5

14/47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсэг:

“47.7.Ашигт малтмалыг шууд, эсхүл ашигт агуулгыг нэмэгдүүлэн баяжмал, бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортлоход ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг давхардуулан ногдуулахгүй.”

15/47² дугаар зүйл.Ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр

“47².3. Энэ хуулийн 47².2-т заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордоос олборлон экспортолсон ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр нь энэ хуулийн 47.5, 47.17-д заасны дагуу ногдуулах ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийн 100 хувьтай тэнцүү байна.”

4 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгийн “стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны” гэснийг “ашигт малтмалын нөөц ашигласны тусгай” гэж, 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн “17.5.Энэ хуулийн 17.4-т заасны дагуу ялгасан” гэснийг “Хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн болон сонгон шалгаруулалт зарлах” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “эрх эдэлнэ” гэснийг “эрх эдэлж, үүрэг хүлээнэ гэж, 35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсгийн “мэдээлнэ” гэснийг “мэдэгдэнэ” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “байгаль орчны менежментийн” гэснийг “байгаль орчныг хамгаалах” гэж, 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсгийн “болон ашиглалтын” гэснийг “ашиглалт болон баяжуулалтын” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1. дэх хэсгийн “болон түгээмэл тархацтай” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын

“, 20” гэснийг, 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгийн “үнэ төлбөргүйгээр” гэснийг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “үйл ажиллагаа явуулж байгаа” гэснийг, 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтын “болон түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар талбай олгох” гэснийг, 11.1.19 дахь заалтын “түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн” гэснийг, 11.1.20 дахь заалтын “түгээмэл тархацтай ашигт малтмалаас бусад төрлийн” гэснийг, 11.1.25 дахь заалтын “сонгон шалгаруулалтын” гэснийг, 17 дугаар зүйлийн гарчгийн “сонгон шалгаруулалтын” гэснийг, 47 дугаар зүйлийн 47.2.1 дэх заалтын “олон улсын” гэснийг, 47.16 дахь хэсгийн “энэ хуулийн 47.7-д заасны дагуу” гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.6, 5.8 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.20 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1.8 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1.6 дахь заалт, 47 дугаар зүйлийн 47.19 дэх хэсэг, 47³ дугаар зүйл, 48 дугаар зүйлийн 48.6.1 дэх заалт, 48.13, 48.14 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

7 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2014 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр батлагдсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл.Стратегийн ач холбогдол бүхий Эрдэнэтийн-Овоо зэс, молибдений ордын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингээс хамаарч үндсэн хувь дээр нэмж ногдуулах хувийг дор дурдсанаар 3 жилийн хугацаатай ногдуулсугай.

№	Ашигт малтмалын нэр төрөл	Хэмжих нэгж	Жишиж үнэлэх бүтээгдэхүүн	Зах зээлийн үнийн түвшин /ам.доллар/	Боловсруулалтаас хамаарч суурь төлбөр дээр нэмж ногдуулах хувь		
					Хүдэр	Баяжмал	Бүтээгдэхүүн
1	Зэс	тн	Зэс /цэвэр металлаар	0-5000 хүртэл	0.00	0.00	0.00
				5000-6000 хүртэл	22.0	11.0	1.00
				6000-7000 хүртэл	24.0	12.0	2.00
				7000-8000 хүртэл	26.0	13.0	3.00
				8000-9000 хүртэл	28.0	14.0	4.00
				9000 ба түүнээс дээш	30.0	15.0	5.00

2 дугаар зүйл.20..... оны ... дугаар сарын-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгогдсон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 20..... оны ... сарын-ны дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шинэчлэн бүртгүүлнэ.

3 дугаар зүйл.Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөө шинэчлэн бүртгүүлэх тухай өргөдлийг гаргасны дараа 30 хоногийн дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг, тусгай зөвшөөрөл олгосноос хойших хугацааны тайлан, төлөвлөгөөг аймаг, нийслэлийн Засаг даргаас татан авч, тусгай зөвшөөрлийн хувийн хэргийн бүрдэл бүрэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг шинэчлэн олгоно.

4 дүгээр зүйл.20..... оны ... дугаар сарын-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө аймаг, нийслэлийн Засаг даргын олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бүртгэхдээ геологи, уул уурхайн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ердийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөс ялгасан тэмдэглэгээ хийнэ.

5 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа гурван жил, хайгуулын тусгай зөвшөөрлийн сунгалт хоёр жилээр нэг удаа байна.

6 дугаар зүйл. Энэ хуульд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг шинэчлэн бүртгүүлээгүй бол тусгай зөвшөөрлийг цуцална.

7 дугаар зүйл. 20.... оны дугаар сарын-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүсэж аймаг, нийслэлийн Засаг даргад ирүүлсэн өргөдлийг Ашигт малтмалын тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл. 20..... оны ... дугаар сарын-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө аймаг, нийслэлийн Засаг даргын олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах нэрээр өөр төрлийн ашигт малтмал хайж, ашигласан нь тогтоогдсон бол тусгай зөвшөөрлийг цуцална.

9 дүгээр зүйл. 20..... оны ... дугаар сарын-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө баригдсан баяжуулах үйлдвэрүүд нь 20..... оны сарын-ны дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад шинэчлэн бүртгүүлнэ.

10 дугаар зүйл. Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэгч баяжуулах үйлдвэрийн тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг гаргасны дараа 30 хоногийн дотор геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг шинээр олгоно.

11 дүгээр зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг:

“10.5.Энэ хуулийн 10.2-т заасан этгээд нь уул уурхайн бүтээгдэхүүний баяжуулалт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээж, экспортлох зорилгоор дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрт биржээр дамжуулан арилжиж болно.”

2/16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг:

“16.3.Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан дотоодын баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд арилжих журмыг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Засгийн газар батална.”

3/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:

“16.4.Энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан бараа хүргэлтийн байршлыг батална.”

2 дугаар зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:

“14.1.Биржийн арилжааны үнийг Олон Улсын худалдааны танхимаас гаргасан худалдааны бараа хүргэлтийн байршилтай уялдуулж тогтооно.”

3 дугаар зүйл. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “... экспортлоход...” гэснийг хассугай:

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2 дахь заалтын "... 47³ дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 10" гэснийг "ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 15" гэж, мөн зүйлийн 59.7 дахь хэсгийн "10 хувийг" гэснийг "30 хувийг" гэж, мөн хэсгийн "аймаг, улсын зэрэглэлтэй хотод" гэснийг "сум, дүүрэгт" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2027 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 он ... дугаар сарын
... өдөр

Улаанбаатар
хот

**ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлд дараах агуулгатай зүйл, хэсэг тус тус нэмсүгэй:

1/12¹ дүгээр зүйл. Удирдлага, зохион байгуулалт

“12¹.1.Баялгийн сангийн төрөлжсөн сангуудын хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлэгч нь Чингис хаан Үндэсний баялгийн сан байна.

12¹.2.Чингис хаан Үндэсний баялгийн сан нь ашгийн төлөө, хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэй 100 хувь төрийн өмчит хуулийн этгээд байна.

12¹.3.Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК нь өөрийн дүрэмтэй, хараат бус удирдлагатайгаар үйл ажиллагаа явуулна. Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК-ийн дүрмийг Монголбанк батална.

12¹.4.Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК-ийн үйл ажиллагааны зардлыг сангийн хөрөнгө оруулалтын орлогоос санхүүжүүлнэ.”

2 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын “зарцуулалт” гэсний өмнө “хөрөнгө удирдлага,” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтын “50 хувиас” гэсний дараа “, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 30 хувиас тус тус” гэж, “12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсгийн “зөвшөөрөл эзэмшигч” гэсний дараа “, түүний үүсмэл ордыг эзэмшигч” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтын “нэгдсэн удирдлагаар хангах” гэснийг “үйл ажиллагааны удирдлага хэрэгжүүлэх” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1.1.а дахь хэсгийн “65 хувь” гэснийг “35 хувь” гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх заалтын “этгээд” гэснийг “этгээдийн төрийн төлөөлөл хэрэгжүүлэгч” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

2025 он ... дугаар сарын
... өдөр

Улаанбаатар
хот

**ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь хэсэгт заасан “төрийн өмчит хуулийн этгээдийг” гэснийг “Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12¹.2 дахь хэсэгт заасан төрийн өмчит хуулийн этгээдийг” гэж, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт “Засгийн газар хэрэгжүүлнэ” гэснийг “Улсын Их Хурал хэрэгжүүлнэ” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 он ... дугаар сарын
... өдөр

Улаанбаатар
хот

**ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөж журмын тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн “Монголбанкаар” гэснийг “Монголбанк болон Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12^{1.2} дахь хэсэгт заасан төрийн өмчит хуулийн этгээд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... - ны өдөр

Улаанбаатар
хот

**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 11¹ дүгээр зүйлийн гарчиг, 11^{1.1} дэх хэсэг, 12.1 дэх хэсэг, 14.1 дэх хэсэг, 28.2.6 дахь заалт, 28.2.7 дахь заалт, 28.2.8 дахь заалт, 32.2 дахь хэсэг, 34.7 дахь хэсэг, 36.1.5 дахь заалт, 43.4 дэх хэсэг, 48.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “цацраг идэвхт изотоп агуулсан” гэсний дараа “газрын ховор элементүүдээс бусад” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын “газрын ховор элемент агуулсан бодисыг” гэснийг, 3 дугаар зүйлийн 3.1.15 дахь заалтын “газрын ховор элемент” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 8.31, 8.32 дахь заалтыг тус тус нэмсүгэй.

8.31. Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа эрхлэх	Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага
8.32. Зураг төсөл боловсруулах зөвшөөрөл	Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага

2 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.20, 8.21, 8.22, 8.23 дахь заалтын “боловсролын” гэснийг “цөмийн энергийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 8.29 дэх заалт 8.30 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс “геологийн судалгаа хийх,” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН
ХАМГААЛАЛТЫН БҮС, ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ,
АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Энэ хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.7 дах хэсгийг нэмсүгэй.

“4.7. Энэ хуулийн 4.1 дэх хэсэгт нуурын давсны орд хамаарахгүй.”

2 дугаар зүйл. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “ашигт малтмал” гэсний дараа “болон чухал ашигт малтмалын” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 33.9 дэх хэсэг нэмсүгэй:

“33.9.Ашигт малтмал хайх, ашиглах зорилгоор олгогдсон талбайтай давхардуулан иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах, эзэмшүүлэх, өмчлүүлэхийг хориглоно.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----oOo-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай 10.31 дүгээр зүйл нэмсүгэй:

“10.31 дүгээр зүйл.Геологи, уул уурхай, газрын тосны үйл ажиллагаанд хууль бусаар халдах

1.Геологи, уул уурхай, газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд хууль бусаар халдаж, тоног төхөөрөмж эвдсэн, үйлдвэрлэлийг санаатайгаар тасалдуулсан, зам, уурхайн гарц хаасан, цахилгаан хангамж, усан хангамжийг зориуд тасалсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлээс болж үйлдвэрлэл 24 цагаас дээш тасалдсан, эсхүл эдийн засгийн ноцтой хохирол учирсан бол хүнийг нэг мянган зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтын “10.28” гэсний дараа “, 10.31” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

----o0o-----